



МОНГОЛЫН

**ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМЫН**

**ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАР ТАНХИМ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ**

2026 оны 05 сарын 07 өдөр

№005

Орхон аймаг

Энэхүү хамтын ажиллагааны Санамж бичиг /цаашид “Санамж бичиг” гэх/-ийг МҮХАҮТ-ын Орхон салбар танхим (цаашид “Танхим” гэх), нөгөө талаас Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо (цаашид “АЖМХ” гэх) байгууллагуудыг (хамтад нь ‘Талууд’ гэх) төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хоёр байгууллагын үйл ажиллагааны зорилго, эрхлэх асуудлын хүрээнд бизнесийн орчныг сайжруулах, аялал жуулчлал, жижиг дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих, бүтээмжийг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажиллахаар байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Талууд Монгол Улсын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, ажлын байрыг хадгалах замаар экспортыг дэмжиж, дундаж давхаргын өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор бизнесийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахад Санамж бичгийн зорилго оршино.
- 1.2 Санамж бичиг нь Талуудын дагаж мөрдөж буй аливаа дүрэм, журамд нийцсэн бөгөөд Санамж бичиг байгуулах болсон үндэслэл, шалтгаан нөхцөлийн талаар талууд бүрэн ойлголцсон болно.
- 1.3 Талууд хамтын ажиллагаандаа нээлттэй, ил тод, шударга байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан зөвшилцөх, бие биедээ хүндэтгэлтэй хандах зарчмыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.4 Энэхүү Санамж бичиг нь Талууд цаашдын харилцаандаа дагаж мөрдвөл зохих үндсэн баримт бичиг болох бөгөөд санхүүгийн болон хууль эрх зүйн аливаа үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ


- 2.1. Санамж бичгийн хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллана:
 - 2.1.1. Танхимаас явуулж буй эдийн засаг, бизнесийн хууль эрхзүй болон бодлогын өмгөөлөлтэй холбоотой судалгаанд идэвхтэй оролцох;
 - 2.1.2. Танхимын гишүүн компаниуд, хувиараа бизнес эрхлэгчдэд аялал жуулчлалын салбарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах;
 - 2.1.3. Талууд жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарыг эрчимтэй хөгжүүлэх, хөрөнгө оруулалт өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд бизнес эрхлэгчдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, чадавхжуулах аливаа сургалт, уулзалт, зөвлөгөөн, үзэсгэлэн худалдааг хамтран зохион байгуулах;

- 2.1.4. Талууд үндэсний томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг оролцуулахад анхаарах;
 - 2.1.5. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр Талууд өөрсдийн мэдээллийн сувгуудаар харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллах;
 - 2.1.6. Эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, салбарын мэдээ мэдээлэл, судалгаа, тоон мэдээллийг харилцан солилцох;
 - 2.1.7. Талууд санамж бичгийн хэрэгжилтийг өөрсдийн гадаад болон дотоодын орон нутаг дахь салбар, төлөөлөгчийн газар, ажилтнаар дамжуулан бүх шатанд хангаж ажиллах;
 - 2.1.8. Талууд сургагч багш, мэргэжилтнээр хангах болон гарын авлагыг боловсруулах;
 - 2.1.9. Бизнес аялал зохион байгуулах
 - 2.1.10. Олон улсын стандарт, арга зүйг нэвтрүүлэх;
- 2.2 Энэхүү Санамж бичгийн хүрээнд хийгдэх ажлуудыг Талууд тухайн чиглэл бүрээр нарийвчлан тохиролцож, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд хоорондын харилцаанд энэхүү Санамж бичгийн үндсэн зарчмыг баримтална.

ГУРАВ. БУСАД

- 3.1 Энэхүү хамтын ажиллагааны Санамж бичгийг 2 хувь үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 3.2 Талууд Санамж бичигт харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Санамж бичгийн адил хүчин төгөлдөр байна.
- 3.3 Санамж бичгийн хүрээнд харилцан солилцсон мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй байна.
- 3.4 Талууд санамж бичгийн хүрээнд ажлын төлөвлөгөө хамтран боловсруулж, хариуцах нэгж, ажилтнуудыг тодорхойлж, хэрэгжилтийг жил тутам дүгнэнэ.

МУХАУТ-ЫН ОРХОН АЙМАГ ДАХЬ
САЛБАР ТАНХИМЫН ДАРГА
М. ГАНБАТ



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.НАРАНГЭРЭЛ

